



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
А.ЛХАГВАСҮРЭН ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgovi@audit.gov.mn

2016.10.27 № 01/155

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Дундговь аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2016 оны 3 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн завсрын аудитаар ажилтнуудын ээлжийн амралтын олговрыг тооцохдоо хоол, унааны хөнгөлөлтийг цалин хөлсний бүрэлдэхүүнд оруулж нийт 29,874,000.00 /Хорин есөн сая найман зуун далан дөрвөн мянга/ төгрөгөөр илүү бодсон зөрчил илэрлээ.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 55.2-т /Ээлжийн амралтын олговрыг ажилтны тухайн ажлын жилийн дундаж цалин хөлсний хэмжээгээр тогтооно/, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2005 оны 55 дугаар тушаалын "Дундаж цалин хөлс тодорхойлох журам"-ын 4-т /... унаа, түлш, байр, хоолны үнийн хөнгөлөлтийг ажилтны цалин хөлсний бүрэлдэхүүнд оруулахгүй/ заасныг тус тус зөрчсөн.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол улсын Ерөнхий аудиторовын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.7-д /Хууль тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал / заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Цаашид ажилчдын дундаж цалинг тодорхойлохдоо хоол, унааны хөнгөлөлтийг оруулж тооцохгүй байх, аудитын явцад өгсөн зөвлөмжийн дагуу холбогдох хууль, тогтоомжийг мөрдөж ажиллах;

1000000712

2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Аудитын газарт 2016 оны 12 дугаар сарын 01-ны дотор албан ёсоор ирүүлэхийг Шүүхийн тамгын газрын дарга /А.Лхагвасүрэн/, нягтлан бодогч /Т.Батмөнх/ нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:

АУДИТЫН ГАЗРЫН
ГАЗРЫН

ШИНЖЭЭЧ



Ж.УГТАХБАЯР

ДАРГА

НЯГТЛАН БОДОГЧ

ЗӨВШӨӨРСӨН:

ШҮҮХИЙН ТАМГЫН

АЛХАГВАСҮРЭН

Т.БАТМӨНХ



¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.